



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/449

Арвайхээр

Захирамжид нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.3, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Орон тооны жишиг норматив батлах тухай” А/024/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон тоо батлах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/68 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулиудын багш ажиллагсдын орон тоо”-ны 29 дэх хэсгийн Уянга сумын Жаргалант багийн ерөнхий боловсролын сургуулийн багш 26 гэснийг 27 гэж, 16 дахь хэсгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн багш 52 гэснийг 55 гэж, 24 дэх хэсгийн Төгрөг сумын ерөнхий боловсролын сургуулийн багш 30 гэснийг 31 гэж, 6 дахь хэсгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн багш 68 гэснийг 70 гэж, 17 дахь хэсгийн Бүрд сумын ерөнхий боловсролын сургуулийн багш 21 гэснийг 22 гэж, 2 дахь хэсгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн багш 110 гэснийг 112 гэж, 27 дахь хэсгийн Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуулийн багш 29 гэснийг 30 гэж, 3 дахь хэсгийн лаборатори Мэргэд сургууль сэтгэл зүйч 0 гэснийг 1 гэж, 15 дахь хэсгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн багш 35 гэснийг 38 гэж, 8 дахь хэсгийн Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн багш 57 гэснийг 58 гэж, хоёрдугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулиудын 2021 оны түр ажиллах орон тоо”-ны 3 дахь хэсгийн Арвайхээр сумын 5 дугаар сургууль хоол зүйч 0 гэснийг 1, 5 дахь хэсгийн лаборатори Мэргэд сургууль хоол зүйч 0 гэснийг 1 гэж, 15 дахь хэсгийн Уянга сумын 2 дугаар сургууль хоол зүйч 0 гэснийг 1 гэж, 7 дахь хэсгийн Хархорин сумын 2 дугаар сургууль хоол зүйч 0 гэснийг 1 гэж, 18 дахь хэсэгт Арвайхээр сумын 1 дүгээр сургууль үйлчлэгч 0 гэснийг 1 гэж, 18 дахь хэсэгт Арвайхээр сумын 1 дүгээр сургууль манаач жижүүр 0 гэснийг 1 гэж, 8 дахь хэсэгт Хархорин сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль үдийн цайны тогооч туслах тогооч 1 гэснийг 2 гэж, гуравдугаар хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2021 оны багш, ажиллагсдын орон тоо”-ны 17 дахь хэсгийн Хархорин сумын сумын цогцолбор 3 дугаар цэцэрлэг хүмүүжлийн багш 7 гэснийг 8 гэж, дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын түр ажиллах орон тоо”-ны 12 дахь хэсэгт Уянга сумын 1 дүгээр цэцэрлэгийн манаач, жижүүр 0 гэснийг 1 гэж тус тус өөрчлөн нэмсүгэй.

2.Батлагдсан орон тоог 2021 оны төсвийн жилд мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

011100951

D:My Doc. Zahiramj. Zasag darga

2.

3.Батлагдсан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

4.Дээрх байгууллагуудын бүтэц, орон тоонд орсон өөрчлөлттэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/68 дугаар захирамжийн 1, 2, 3 дугаар хавсралтуудын хамаарах заалтыг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

